



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Бөртэ ТӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** СНАГ-2024/98/НА-СТА-ТӨА

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2024 он</p>	<p>Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663      Цахим хаяг: <a href="mailto:naranchimegts@audit.gov.mn">naranchimegts@audit.gov.mn</a> Аудитын менежер: Б.Лхагвацэнд Утас: 261885      Цахим хаяг: <a href="mailto:lkhagvatsendb@audit.gov.mn">lkhagvatsendb@audit.gov.mn</a> Ахлах аудитор: Д.Цэгмиддорж Утас:263533      Цахим хаяг: <a href="mailto:tsegmiddorjd@audit.gov.mn">tsegmiddorjd@audit.gov.mn</a> <u>Аудитор:</u> Ч.Дашдаваа Утас: 263533      Цахим хаяг: <a href="mailto:dashdavaach@audit.gov.mn">dashdavaach@audit.gov.mn</a></p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



БӨРТЭ ТӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ,  
ДЭД ХУРАНДАА Б.ГАНЖИГҮҮР ТАНАА

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2024.03.15

№

04/409

танай

-ны №

-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Бөртэ ТӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бөртэ ТӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт байрлах 50 хүн хүлээн авах хүчин чадалтай амралт, үйлчилгээний газрын барилгыг улсын комисс хүлээн авсан боловч үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл аваагүй, Батлан хамгаалахын сайдын /хөрөнгөд бүртгэх/ тушаал гараагүйгээс дуусаагүй барилга данснаас үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэж аваагүй байна.

### Аудитын гол асуудал

Тайлант онд нийт орлогыг 5,548.6 сая төгрөгөөр, нийт зардлыг 5,363.7 сая төгрөгөөр эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталж, гүйцэтгэлээр 6,824.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 6,256.2 сая төгрөгийн зардал гарган, 568.2 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

### Бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын тайлант онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөний чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгасан 54 хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт 85.7 хувьтай байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,935,107,167.07	1,268,184,369.35
1.1.2	Дансны авлага	114,718,547.86	376,715,006.40
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	578,716.60	420,550,109.24
1.1.4	Бусад авлага	79,098,889.60	79,780,185.27
1.1.6	Бараа материал	2,221,712,869.69	3,392,560,937.32
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	425,783,625.77	257,794,640.07
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>4,776,999,816.59</b>	<b>5,795,585,247.65</b>
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,751,554,702.10	1,672,174,081.36
1.2.2	Биет бус хөрөнгө	183,936,345.12	152,161,092.51
1.2.9	Дуусаагүй барилга	603,426,075.92	603,426,075.92
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>2,538,917,123.14</b>	<b>2,427,761,249.79</b>
<b>1.30</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>7,315,916,939.73</b>	<b>8,223,346,497.44</b>
2.1.1.1	Дансны өглөг	37,350,395.09	385,396,989.05
2.1.1.3	Татварын өр	211,148,122.74	719,315,208.13
2.1.1.4	НДШ - ийн өглөг	-	55,216,182.83
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	1,115,347,396.12	543,105,778.00
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>1,363,845,913.95</b>	<b>1,703,034,158.01</b>
<b>2.20</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>1,363,845,913.95</b>	<b>1,703,034,158.01</b>
<b>2.30</b>	<b>Эздийн өмч</b>	<b>733,445,573.35</b>	<b>733,445,573.35</b>
2.3.1	төрийн	733,445,573.35	733,445,573.35
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	869,113,198.36	869,113,198.36
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	70,118,900.00	70,118,900.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	4,279,393,354.07	4,847,634,667.72
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>5,952,071,025.78</b>	<b>6,520,312,339.43</b>
<b>2.40</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>7,315,916,939.73</b>	<b>8,223,346,497.44</b>

### 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	6,329,442,904.37	6,718,759,778.17
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	4,323,218,474.82	5,053,065,506.69
<b>3</b>	<b>Нийт ашиг ( алдагдал)</b>	<b>2,006,224,429.55</b>	<b>1,665,694,271.48</b>
5	Хүүгийн орлого	3,239,608.96	34,879,014.25
8	Бусад орлого	74,376,583.41	70,772,762.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	4,012,854.55	20,418,932.91
10	Ерөнхий ба удирдлагын зардал	933,539,978.84	902,619,328.42
12	Бусад зардал	62,211,209.15	183,015,595.81
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-887,598.44	-5,604.38
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-43,017.77	-13,571,659.92
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>1,083,145,963.17</b>	<b>651,714,926.29</b>
19	Орлогын татварын зардал	113,241,500.86	83,473,612.64

**Бөртэ ТӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

<b>20</b>	<b>Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>969,904,462.31</b>	<b>568,241,313.65</b>
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>969,904,462.31</b>	<b>568,241,313.65</b>
<b>24</b>	<b>Нийт дэлгэрэнгүй орлогын дүн</b>	<b>969,904,462.31</b>	<b>568,241,313.65</b>

**2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	581,776,709.35	667,886,485.36	70,118,900.00	3,192,293,977.00	4,512,076,071.71
3	Залруулсан үлдэгдэл	581,776,709.35	667,886,485.36	70,118,900.00	3,192,293,977.00	4,512,076,071.71
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	969,904,462.31	969,904,462.31
6	Өмчид гарсан өөрчлөлт	151,668,864.00	-	-	117,194,914.76	268,863,778.76
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	201,226,713.00	-	-	201,226,713.00
9	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	733,445,573.35	869,113,198.36	70,118,900.00	4,279,393,354.07	5,952,071,025.78
11	Залруулсан үлдэгдэл	733,445,573.35	869,113,198.36	70,118,900.00	4,279,393,354.07	5,952,071,025.78
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	568,241,313.65	568,241,313.65
17	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	733,445,573.35	869,113,198.36	70,118,900.00	4,847,634,667.72	6,520,312,339.43

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
<b>1.10</b>	<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>7,165,715,491.54</b>	<b>6,898,857,262.56</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	7,148,043,913.54	6,867,121,460.56
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	13,327,538.00	10,009,152.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	4,344,040.00	21,726,650.00
<b>1.20</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>5,753,600,172.35</b>	<b>7,535,392,330.15</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,683,803,579.55	2,000,185,898.49
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	477,449,378.32	476,632,330.68
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	2,556,420,309.30	3,864,578,346.70
1.2.4	Ашиглалтын зардал төлсөн	52,267,587.18	113,400,737.35
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	22,789,055.00	18,395,839.00
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	-	18,000.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	518,709,736.46	459,329,276.80
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	2,658,000.00	-
1.2.9	Бусад мөнгөн зарлага	439,502,526.54	602,851,901.13
<b>1.30</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>1,412,115,319.19</b>	<b>(636,535,067.59)</b>
<b>2.10</b>	<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>4,006,343.96</b>	<b>84,045,115.25</b>
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	766,735.00	49,166,101.00
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	3,239,608.96	34,879,014.25
<b>2.20</b>	<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>840,153,529.00</b>	<b>79,424,716.00</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	745,288,357.00	32,009,000.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	28,654,000.00	-
2.2.5	Бусад олгосон зээл болон урьдчилгаа	66,211,172.00	47,415,716.00

**Бөртэ ТӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

<b>2.30</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(836,147,185.04)</b>	<b>4,620,399.25</b>
<b>3.10</b>	<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>314,290,304.76</b>	<b>(35,002,525.00)</b>
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	66,211,172.00	-
3.1.3	Төрөл бүрийн хандив	248,079,132.76	(35,002,525.00)
<b>3.30</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>314,290,304.76</b>	<b>(35,002,525.00)</b>
<b>4.00</b>	<b>Валютын ханшийн зөрүү</b>	<b>(14,027,148.14)</b>	<b>(5,604.38)</b>
<b>4.10</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>876,231,290.77</b>	<b>(666,922,797.72)</b>
<b>5.00</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>1,058,875,876.30</b>	<b>1,935,107,167.07</b>
<b>6.00</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>1,935,107,167.07</b>	<b>1,268,184,369.35</b>

**2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2022 оны гүйцэтгэл	2023 оны		Өсөлт /+/, бууралт /-	
		Зорилтот түвшин	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Нийт орлого	6,407,059,096.74	5,548,550,000.00	6,824,411,554.42	(1,275,861,554.42)	23.0
Нийт зардал	5,323,913,133.57	5,363,717,926.40	6,256,170,240.77	(892,452,314.37)	16.6
Үүнээс: а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	4,323,218,474.82	4,262,632,296.00	5,053,065,506.69	(790,433,210.69)	18.5
б) Удирдлагын зардал	933,539,978.84	783,702,733.76	902,619,328.42	(118,916,594.66)	15.2
Үндсэн нэмэгдэл цалин	675,164,139.57	482,581,392.00	582,113,963.92	(99,532,571.92)	20.6
Нийгмийн даатгалын шимтгэл	78,015,091.73	74,800,115.76	89,811,874.06	(15,011,758.30)	20.1
Нормын хувцас	2,109,009.49	2,575,279.00	2,541,207.34	34,071.66	1.3
Түлш шатахуун	4,969,808.74	4,590,768.00	4,601,531.64	(10,763.64)	0.2
Ашиглалтын зардал	1,979,325.43	2,304,550.00	-	2,304,550.00	100.0
Засвар үйлчилгээ	6,354,090.91	738,000.00	691,500.00	46,500.00	6.3
Шуудан холбоо	1,130,493.08	261,290.00	167,207.12	94,082.88	36.0
Бичиг хэргийн зардал	8,061,920.53	4,737,500.00	7,803,941.36	(3,066,441.36)	64.7
Тээврийн хэрэгслийн татвар	131,900.00	-	-	-	0.0
Үндсэн хөрөнгийн элэгдэл	82,750,730.01	120,850,000.00	120,774,581.19	75,418.81	0.1
Цэвэрлэгээ үйлчилгээ	60,000.00	585,974.00	-	585,974.00	100.0
Хүлээн авалт	40,464,318.18	6,750,000.00	6,664,020.79	85,979.21	1.3
Мэргэжлийн үйлчилгээ	16,881,392.64	11,118,432.00	10,955,239.86	163,192.14	1.5
Томилолт	392,000.00	56,891,276.00	56,818,400.54	72,875.46	0.1
Аж ахуйн зардал	714,169.92	985,509.00	-	985,509.00	100.0
Албан татвар төлбөр хураамж	905,680.00	172,048.00	161,900.00	10,148.00	5.9
Ажиллагсад олгосон шагнал урамшуулал	4,500,000.00	5,750,000.00	5,550,000.00	200,000.00	0.0
Бусад зардал	8,955,908.61	8,010,600.00	13,963,960.60	(5,953,360.60)	74.3
с) Борлуулалт, маркетингийн зардал	4,012,854.55	6,559,524.00	20,418,932.91	(13,859,408.91)	211.3
Томилолт	65,454.55	1,759,524.00	459,700.00	1,299,824.00	73.9
Мэргэжлийн үйлчилгээ	330,000.00	-	16,330,845.36	(16,330,845.36)	-
Түлш шатахуун	-	2,000,000.00	1,021,146.46	978,853.54	48.9

**Бөртэ ТӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

Бусад зардал	3,617,400.00	2,800,000.00	2,607,241.09	192,758.91	6.9
Бусад	13,829,762.16	-	-	-	0.0
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	43,017.77	15,300,000.00	13,571,659.92	1,728,340.08	11.3
Татвар суутгах орлого	1,132,415,008.60	480,355,446.24	834,736,126.48	(354,380,680.24)	73.8
Орлогын албан татвар	113,241,500.86	38,420,230.40	83,473,612.64	(45,053,382.24)	117.3
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	887,598.44	-	5,604.38	(5,604.38)	0.0
d) Бусад зардал	48,381,446.99	207,103,142.24	183,015,595.81	183,015,595.81	88.4
Татварын өмнөх ашиг	1,083,145,963.17	223,252,304.00	651,714,926.29	(428,462,622.29)	191.9
Цэвэр ашиг/алдагдал	969,904,462.31	184,832,073.60	568,241,313.65	(383,409,240.05)	207.4
Төрийн өмчит төвлөрүүлэх ашиг	-	50,000,000.00	20,000,000.00	30,000,000.00	60.0
Борлуулалтын нэг төгрөгт ногдох зардал	0.68	0.78	0.75	0.03	3.8
Хөрөнгө оруулалт	481,900,000.00	400,083,000.00	-	400,083,000.00	100.0
Нийт ажиллагсдын тоо	161.00			-	
Нийт цалингийн сан	2,054,330,294.84	2,010,755,800.00	2,432,667,872.68	(421,912,072.68)	21.0

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар дансны бичилт буруу хийсэн 32.1 сая төгрөгийн 1, бараа материал, мал сүргийн орлого зарлага дутуу бүртгэсэн 3.3 сая төгрөг 2, нийт 35.4 сая төгрөгийн 3 алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа.

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн дансанд 32,148.5 мянган төгрөгийн 26 нэр төрлийн эд хөрөнгийг ангилал зөрүүлэн бүртгэсэн байна.	1	32,148.5			1	32,148.5	1	32,148.5		
Татан буугдсан Цагаан шонхор ТӨААТҮГ-аас ирсэн 937.6 мянган төгрөгийн бараа материалыг 2022 оны жилийн эцсийн тайланд дутуу бүртгэсэн байна.	1	937.6	1	937.6			1	937.6		
Мал сүргээс 40 толгой хязаалан насны хонийг нас дэвшүүлж нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй 400.0 мянган төгрөг, санхүүгийн тайланд тайлант хугацааны малын орлого зарлагыг бүртгээгүй 2,010.0 мянган төгрөг нийт 2410.0 мянган төгрөгийг бүртгэж тайлагнаагүй байна.	1	2,410.0	1	2,410.0			1	2,410.0		
Дүн	3	35,496.1	2	3,347.6	1	32,148.5	3	35,496.1	-	-

**Бөртэ ТӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

Аудитаар нийт 29.3 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 20.0 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 9.3 сая төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бөртэ ТӨААТҮГ-ын 2023 оны батлагдсан бизнес төлөвлөгөөнд Батлан хамгаалах яамны "Зэвсэгт хүчний хөгжлийн сан" -д 50.0 сая төгрөг төвлөрүүлэхээр батлагдсан. Бөртэ ТӨААТҮГ нь БХЯ-ны подвалын засварыг гүйцэтгүүлэхээр хуулийн этгээдтэй гэрээ байгуулж 20.0 сая төгрөгийг "Зэвсэгт хүчний хөгжлийн сан"-д шилжүүлэлгүй шууд зарцуулсан бөгөөд Батлан хамгаалах яамны Зэвсэгт хүчний хөгжлийн санд төвлөрүүлснээр тайлагнасан байна.	1	20,000.0	1	20,000.0		
Бөртэ ТӨААТҮГ нь Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 1в/623 дугаар албан бичгээр өгсөн зөвшөөрлийн дагуу Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт байрлах Амралтын газрын бүтээн байгуулалтын ажлыг бизнес төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнээс давсан орлогоос санхүүжүүлэн 603,426,075.92 төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг хийж гүйцэтгэн 50 хүн хүлээн авах хүчин чадалтай амралт, үйлчилгээний газрыг барьж байгуулан улсын комисст хүлээлгэн өгсөн ч Батлан хамгаалахын сайдын хөрөнгө бүртгэх зөвшөөрөл гараагүй, дуусаагүй барилга данснаас үндсэн хөрөнгө-барилга дансанд бүртгэн аваагүй байна.	1	-	1	-		
Нэг иргэнээс авах 2,617.3 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн акт үйлдэж баталгаажуулаагүй байна.	1	2,617.3			1	2,617.3
"Цагаан шонхор" оёдлын үйлдвэрийн барилгын их засварт 190,576.1 мянган төгрөг зарцуулж, урьдчилж төлсөн зардал дансанд бүртгэсэн байна. Тайлант онд Бөртэ ТӨААТҮГ-ын 1/25 дугаар албан бичгээр уг барилгыг капиталжуулах хүсэлтээ Батлан хамгаалахын сайдад гаргасан боловч капиталжуулах зөвшөөрөл гараагүй байна.	1	-			1	-
Цэргийн хувцас үйлдвэрлэлийн Үйлдвэрлэлийн нэмэгдэл зардалд дараах үйл ажиллагааны зардлыг хуримтлуулан бүртгэсэн байна. Үүнд: Амралтын газарт түлшний мод хүргэсэн тээврийн зардал 2,143,777.38 төгрөг, Амралтын газрын түлшний модны үнэ 4,554,165.00 төгрөг, нийт 6,697,942.38 төгрөг ҮНЗардалд буруу хуваарилсан байна.	1	6,697.9			1	6,697.9
Бөртэ ТӨААТҮГ нь оёдлын үйлдвэрлэл явуулдаг бөгөөд үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд зардлын бүртгэл хөтөлж тайлагнадаг. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт зардлын бүртгэл /ББӨ, ҮНЗ, ДҮ, ШХ/-ийн талаар баримтлах бодлого дутуу тусгагдсан байна.	1	-			1	-
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>29,315.2</b>	<b>2</b>	<b>20,000.0</b>	<b>4</b>	<b>9,315.2</b>